



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Булган-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 68,850,416.00 (жаран найман сая найман зуун тавин мянга дөрвөн зуун арван зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Булган-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Пүрэвдэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 05 дугаар сарын 20-ны
өдрийн 123 дугаар тогтоолын хавсралт



**"Булган-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Донг маркийн, 93-21 БУА улсын дугаартай, өөрөө буулгагч, арлын дугаар - LGAWAHAN996604034	2009	34,425,208.00
2	Донг маркийн, 93-22 БУА улсын дугаартай, өөрөө буулгагч, арлын дугаар - LGAWAHAN6966055	2009	34,425,208.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		68,850,416.00 (жаран найман сая найман зуун тавин мянга дөрвөн зуун арван зургаан)